

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	0
2. Аудитын тайлан.....	1
2.1 Оршил	1
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	2
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	3
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	3
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	4
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	4
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	5
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	5
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	5
2.11 Шилэн дансны мэдээлэл	6
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	6
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	6
Менежментийн захидал	8
3.1 Балансын данстай холбоотой асуудал.....	8
3.2 Балансын данстай холбоотой асуудал.....	9
3.3 Дотоод аудит.....	9
3.4 Зардлын данстай холбоотой асуудал	10
3.5 Зардлын данстай холбоотой асуудал	10
3.6 Балансын данстай холбоотой асуудал.....	10
3.7 Дотоод аудит.....	11
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийгдсэн Мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Т.МӨНХСАЙХАН ТАНАА

2019.02.25 № 06/249
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Т.Мөнхсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018.10.29-наас 2019.02.18-ны өдрүүдэд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Баян ташаагийн эх Аудит” ХХК-ийн аудитор Т.Хоролсүрэн, Д.Түмэндэмбэрэл, чанарын хяналтын менежер Ч.Чимгээ, аудиторын туслах Д.Балжирдорж, Г.Хишигдулам нар хариуцаж хэрэгжүүлэв.

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Баян ташаагийн эх Аудит” ХХК-д 2019.01.25-ны өдрийн 67 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Гэмтэл, согог судлалын үндэсний төв нь “Ээлтэй эрсдэлгүй орчинд, мэргэшсэн хамт олон, дэлхийн жишигт нийцсэн оношилгоо үйлчилгээг үзүүлнэ.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Эрүүл мэндийн яамнаас тодорхойлсноор Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гэмтэл согогын чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн болон лавлагаа тусламж үйлчилгээ

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журмын дагуу өөрчлөлт оруулсан байна.

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Гэмтэл, согог судлалын үндэсний төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн Acolous програм хангамж ашигладаг байна.

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” гэж үзлээ.

Тус эмнэлэг нь эмнэлэгийн тусламж үйлчилгээ, сувилахуйн тусламж үйлчилгээ, хүний нөөцийн хөгжил ,төсөв санхүү, эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах, дотоод хяналтыг эрчимжүүлэх зорилгоор Чанар дотоод хяналтын албыг байгуулан ажиллаж байна. Тус алба нь мэргэжлийн байгууллагууд болон байгууллагын удирдлагын зөвлөл, тасаг албадын дарга нартай хамтран чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд тус албанд шинээр Хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэнг авч ажиллуулж эхэлсэн.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж,

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 16 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төсөвт байгууллага нь үйл ажиллагааны нийт зардлаа төсөвлөж, үүний дагуу өөрийн үйл ажиллагаанаас болон төсвөөс орлого төвлөрүүлэн зардлаа санхүүжүүлдэг. Ашгийн бус зардалд суурилан санхүүгийн үр дүнг төсөвлөдөг байгууллагын хувьд нийт зардлыг суурь болгон авч үзэх нь тохиромжтой юм.

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2018 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 30,491,565.9 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 304,915.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн бөгөөд аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөг/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	7	396,824.30	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	11,734.40	
	Дүн	9	408,558.70	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал
Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

Өндөр өртөгт хиймэл түнхний бүтэн үений хагалгаанд зарцуулсан 6,894.7 мянган төгрөгийн үнэтэй 1 ширхэг түнхний бүтэн үеийг 2 шаардах хуудас бичиж давхар зарлагадсан байна.

Энэ нь “иж бүрэн байдал”, “үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

2. Зардлын данстай холбоотой асуудал

Тухайн оны 12 дугаар сард ээлжийн амралттай болон ажлын хоног дутуу ажилласан 35 хүнд нийт 4,839.7 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Төлбөрийн акт тогтоох

Дээрх актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 1-ны дотор ирүүлнэ үү.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дараагийн аудитаар өндөр өртөгт эм эмнэлгийн хэрэгсэл, цалин, тендерийн талаар авч үзнэ.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал үгүй байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Гэмтэл, согог судлалын үндэсний төв чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, 5 арга хэмжээнд зориулан 2018 онд 30,083,992.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 94.7 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 16,384.2 мянган төгрөг буюу 0.06 хувь, бараа үйлчилгээний бусад зардал /өндөр өртөгт тусламж үйлчилгээний зардал/ 1,672,852.8 мянган төгрөг буюу 5.24 хувиар зардал хэмнэсэнтэй холбоотой байна. Энэ нь 2018 онд цэвэр, бохир усны үргүй зардлыг бууруулах зорилгоор эвдэрсэн крант, ариун цэврийн өрөө, душ тус бүрийг засварлаж ажилласан. Мөн 2017, 2018 онд дулаан алдагдлыг бууруулах зорилгын хүрээнд засвар үйлчилгээг тогтмол хийж ажилласнаар түлш, халаалтын зардалд хэмнэлт үүссэн байна. Бараа үйлчилгээний бусад зардал /өндөр өртөгт тусламж үйлчилгээний зардал/-ын хувьд хувь хүн өөрөө төлөх төлбөр буюу үндсэн үйл ажиллагааны орлого тасалдсаны улмаас хэмнэлт үүссэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буурсан шалтгаан нь өндөр өртөгт тусламж үйлчилгээний хувь хүн өөрөө төлбөх төлбөр нь эрүүл мэнд, даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу хэрэгслийн үнийн дүнгийн 25 хувиар тооцож төсөв баталдаг хэдий ч тендер шалгаруулалтын үр дүнд дээрх хувьд хүрээгүй дунджаар 12.5 хувиар тооцсон дүнгээр хувь хүн төлбөрөө төлснөөс үүссэн.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Гэмтэл, согог судлалын үндэсний төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100% хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн (САГ-2019/391/СТА-ТШЗ)

Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл өмнөх оны аудитлагдсан тайлангийн эхний үлдэгдлээс 729.6 мянган төгрөгөөр зөрүүтэй. Аудитлагдсан санхүүгийн тайлан гарснаас хойш төвлөрүүлсэн шилжүүлгийг Эрүүл мэндийн яамнаас авлагаар тусгуулсан.

Энэ нь “тасалбар болголт” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан эхний үлдэгдэл өмнөх оны аудит хийсэн тайлангаас зөрүүтэй, эхний эцсийн үлдэгдэл тодруулга тайланд зөрүүтэй тусгагдсан байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Аудитлагдсан санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг өөрчлөхгүй байх, цаашид тайлан гарахаас нь өмнө буюу тайлант хугацаанд нь тооцоо нийлж баталгаажуулж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2017 оны аудитлагдсан жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 729.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн бөгөөд буцаан олгох дүнгээр тооцоогүй тул авлагаар бүртгээгүй байсан. 2018 оны 1-р сард дээрх төвлөрүүлсэн үлдэгдэл нэмэлт санхүүжилтийн 100900020418 тоот дансанд эргэж орсон бөгөөд салбарын хэмжээний нэгтгэсэн тайланд тусгах шаардлагатай болсон тул аудитлагдсан тайлангийн татаас санхүүжилтийн авлагын дансанд өөрчлөлт орсон болно.

3.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.2.1 Илрүүлэлт:

Машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэх 63,822.8 мянган төгрөгийн үнэтэй 44 нэр төрлийн хөрөнгийг буруу ангилан тавилга эд хогшлын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар журмыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл тодруулга тайлан тооллогын дүнгээс зөрүүтэй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар журмыг мөрдөж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Данс андуурч бүртгэлд тусгасан 63,822.8 мянган төгрөгний үнэтэй хөрөнгийг жагсаалтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар албан бичгээр хүргүүлж, шийдвэрлүүлж 2019 оны эхний хагас жилийн тайлан балансад тусган ажиллана.

3.3 ДОТООД АУДИТ

3.3.1 Илрүүлэлт:

Хөтөлбөр, арга хэмжээний зардлаас 20,381.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн кассын данснаас 104,374.9 мянган төгрөгийг Жижиг мөнгөн сангийн дансанд татан зарцуулалт хийсэн байна.

Энэ нь “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл банкны үлдэгдэлтэй тохирохгүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулж байх, Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2018 онд Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 2.2-д “Төсвийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картын дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгийг төрийн сангаас баталсан хязгаар /Жижиг мөнгөн сан/-ийн дотор шилжүүлэн авч болох бөгөөд гадаад, дотоод албан томиллолт, гадаад зочны зардал, тэтгэмж, урамшуулал, шагналыг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн авч болно” гэж заасныг үндэслэн байгууллагын бэлэн мөнгөний кассын дансаар Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн үндэсний байгууллага зэрэг дээд байгууллагаас баталж санхүүжүүлэн хамтран хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд санхүүжигдсэн зардлыг Сангийн сайдын 2013 оны 73 дугаар

тушаалын 2-р хавсралт Маягт №3ЭБ №1 -ын дагуу хүсэлт гарган сангийн яаманд хүргүүлэн зарцуулах эрх нээлгэснээр үйл ажиллагаанд нь зарцуулж ,тайланг холбогдох газруудад хүргүүлэн тайлагнан санхүүгийн тайланд тусгасан болно.

3.4 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.4.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн шинжтэй 1,299.9 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалд орлогод авч шууд зардалд бичсэн байна.

Энэ нь “толилуулга ба тодруулга” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралт Төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар журмыг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Хөрөнгө шамшигдах, санхүүгийн тайлан мэдээ буруу гарах

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралт Төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар журмыг мөрдөж ажиллах

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

1,299.9 мянган төгрөгийн үнэтэй 1 ширхэг бага оврын хөргөгч, 1 ширхэг дээжний хөргөгчийг худалдан авч бараа материалын дансанд буруу бүртгэсэн тул 2019 оны эхний хагас жилийн тайлан балансад залруулга хийж бүртгэлд тусган ажиллана.

3.5 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.5.1 Илрүүлэлт:

Тухайн тайлант жилд 12 гэрээт ажилтан ажилласан бөгөөд тэдгээрийн цалингийн зардал 63,863.0 мянган төгрөгийг санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд салгаж тайлагнаагүй.

Энэ нь “толилуулга ба тодруулга” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.

3.5.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан мэдээ буруу гарах

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Гэрээгээр ажиллаж байгаа ажилчдын цалингийн зардлыг үндсэн цалингийн зардлаас салгаж бүртгэж байх, Төсвийн тухай хуулийн 22.1, 22.2.3 дугаар зүйлийг баримталж ажиллах

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үндсэн орон тоондоо багтааж хөлсөөр ажиллах гэрээ байгуулан авч ажиллуулсан мөн төсөвт гэрээт ажилчдын цалин гэж салгаж өгөөгүй тул тайланд тусгахдаа үндсэн цалинд оруулан тайлагнасан болно.

3.6 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.6.1 Илрүүлэлт:

(САГ-2019/391/СТА-ТШЗ)

9,948.1 мянган төгрөгийн онгоцны тийзийг бусад хангамжийн материалын дансаар орлого авч зарлага гаргасан.

Энэ нь “толилуулга ба тодруулга” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн байна.

3.6.2 Эрсдэл:

Бараа материалын тооллого, тооцоог чанаргүй хийх

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Онгоцны тийзийг бараа материалын бус тооцооны дансаар дамжуулан бүртгэж байх

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид алсын дуудлагын онгоцны тийзний үнийг тухайн зардлын дансанд шууд бичилт хийж бүртгэлд тусган ажиллана.

3.7 Дотоод аудит

3.7.1 Илрүүлэлт:

Кассын орлогын 132,404.9 мянган төгрөгийг хуримтлуулан 5-10 хоногийн дараагаар дансанд тушаасан

Энэ нь “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчсөн байна.

3.7.2 Эрсдэл:

Зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү их бэлэн мөнгөнийг удаан хугацаагаар хадгалах

3.7.3 Өгсөн зөвлөмж:

Кассын орлогыг хугацаанд тушааж байх, Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллах

3.7.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Кассын орлого нь орой ажлын цаг тарснаас хойш буюу 17 цагаас хойш тушаагддаг ба тухайн өдрийн орлого нь дараагийн ажлын өдрийн 11 цагийн татан авалтаар байгууллагын дансанд орж хуулганд татагдан харагддаг. 5 дахь өдрийн тушаагдсан орлого нь дараа 7 хоногийн 1 дэх өдрийн 11 цагаас, мөн бүх нийтийн амралтын өдрүүд болон баяр ёслолын өдрүүдээр кассын орлого тушаагдахгүй хуримтлагдан ажлын өдөр тушаагддаг тул кассын үлдэгдэл өндөр дүнтэй, орлого тушаагдаагүй хоног их харагддаг.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 1-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
